

Хагас жил, улирлын үйл ажиллагааны тайлагнал /маягт 2/	
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.	
Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр/	2024 оны 01-р сарын 01-ний өдрөөс 2024 оны 6-р сарын 30-ны өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Премиум Нэксус ХК УБ-ийн дугаар 9007001006 ҮЦ-ны код CUMN Утас 976-7733-0101
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын Хөрөнгийн Бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Хүнсний дэлгүүр, хүнсний үйлдвэрлэл, худалдааны зуучлал, франчайзын гэрээний үндсэн дээр бизнесийн үйл ажиллагаа явуулах, гадаад худалдаа, менежментийн зөвлөх үйлчилгээ
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	1,114,252,034 ширхэг энгийн хувьцаа
Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Бэлтгэсэн: Д.Бүдханд, Санхүүгийн газрын захирал, Бизнес контроллер Хянасан: Г.Чинзориг, Гүйцэтгэх захирлын орлогч
1.	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/
	Санхүүгийн байдлын үзүүлэлт Нийт хөрөнгө : 244,247,900 мянган төгрөг Нийт өр төлбөр : 182,879,772 мянган төгрөг Эздийн өмч : 61,368,128 мянган төгрөг
	Орлогын тайлан Борлуулалтын орлого : 263,631,864 мянган төгрөг Нийт ашиг : 31,099,771 мянган төгрөг Татварын дараах ашиг: 10,652,539 мянган төгрөг
	Өмчийн өөрчлөлтийн тайлан Хувьцаат капитал (+НТК): 157,183,119 мянган төгрөг Хуримтлагдсан ашиг : (99,532,241) мянган төгрөг
	Мөнгөн гүйлгээний тайлан Үйл ажиллагааны цэвэр мөнгөн урсгал : 32,656,957 мянган төгрөг Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн урсгал : (9,754,430) мянган төгрөг Санхүүжилтийн цэвэр мөнгөн урсгал : (18,723,042) мянган төгрөг
2.	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт
	Энэ маягтад хавсаргав.

3.	Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт	
3.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Бэлэн мөнгөний цикл 2024 оны 1-р хагаст (16) хоног байсан. Бараа материалын дундаж наслалт 30 хоног болж сайжирсан бол өглегийн дундаж наслалт 47 хоног байна. Компанийн зүгээс борлуулалтыг нэмэгдүүлэх, бараа материалын дундаж наслалтыг бууруулах ажлуудыг эхний хагас жилд хэрэгжүүлсний үр дүнд уг үзүүлэлт сайжирсан.
3.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	Компанийн эргэлтийн хөрөнгө нь эргэлтийн өр төлбөрөөс бага буюу эргэлтийн харьцаа 0.7 байна. Өрийн харьцаа 0.7 болж буурсан нь нийт хөрөнгө нэмэгдэж, санхүүгийн өр төлбөр буурсантай холбоотой.
3.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл	2024 оны 1-р хагас жилд Премиум Нэксус ХК нь нийт салбарын тоог 19-ээр нэмэгдүүлж 393 салбартай болоод байна.
3.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого	Байхгүй
4.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	
	– 2024 оны 1 сарын 15-нд Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд болох Премиум Конкрит ХХК-аас жилийн 17.1%-ийн хүүтэй, 8 тэрбум төгрөгийн богино хугацаат зээл авч, 2024 оны 1-р хагас жилд гэрээнд заасан хуваарийн дагуу төлж барагдуулсан. – Мөн 2023 оны 12 сарын 19-ны Төлөөлөн удирдах зөвлөлийн 36 тоот тогтоолын дагуу Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд болох Премиум Конкрит ХХК-аас жилийн 17.1%-ийн хүүтэй 5 хүртэл тэрбум төгрөгийн богино хугацаат зээл авч авах шийдвэрийн дагуу 2 тэрбум төгрөгийн зээлийг авч улирлын чанартай эргэлтийн хөрөнгийн дутагдлыг нөхөж ажилласан. 2024 оны 6-р сард тус зээлийг төлж барагдуулсан.	
5.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл	
	– Тайлант хугацаанд нэмж хувьцаа гаргах замаар олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлээгүй. Өрийг хувьцаагаар солих, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авах замаар хаалттай хүрээнд хувьцаа гарган эздийн өмчийг нэмэгдүүлсэн.	
6.	Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл	

1. 2024 оны 04-р сарын 25-ны өдөр хуралдуулсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар Компанийн 2023 оны жилийн үйл ажиллагааны тайлан, тайлангийн талаарх дүгнэлтийг баталж, Компанийн 2023 оны санхүүгийн жилийн цэвэр ашиг (алдагдал)-аас ногдол ашиг хуваарилахгүй тухай шийдвэр, түүний шалтгаантай танилцсан.
2. ТУЗ-ийн хороод нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журам болон Ёс зүйн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, шинээр Шүгэл үлээх журам, Ёс зүйн хорооны үйл ажиллагааны журам батлах, Ёс зүйн хороог байгуулах зөвлөмжүүдийг ТУЗ-д танилцуулсан бөгөөд ТУЗ танилцаад Ёс зүйн хороог байгуулж, дээрх журмуудыг баталж, журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүрэг болгосон.
3. 2023 оны 12-р сарын 04-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын шийдвэр болон Монголын Хөрөнгийн Биржийн 2023 оны 12-р сарын 28-ны өдрийн А/348 тоот тушаал, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2024 оны 01-р сарын 12-ны өдрийн 02 тоот тогтоолын дагуу:
 - а. Нэгж бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 127,632,909 ширхэг энгийн хувьцааг хаалттай хүрээнд 208 төгрөгөөр нэмж гарган 26,547,645,072 төгрөгийн эд хөрөнгийг шилжүүлж авах.
 - б. Нэгж бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 168,850,482 ширхэг энгийн хувьцааг өрийг хувьцаагаар солих хэлбэрээр 208 төгрөгөөр нэмж гарган 35,120,900,256 төгрөгийн зээлийг хаах аргаар нийт нэгж бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 296,483,391 ширхэг энгийн хувьцааг Хаалттай хүрээнд 208 төгрөгөөр гарган нийт 61,668,545,328 төгрөгийн хөрөнгө оруулалтыг татан төвлөрүүлсэн. Энэ ажил гүйлгээний цар хүрээнд Чингис Шар Айраг ХХК, Сэнтрал Коммерс ХХК, Сэнтрал Кофе Рөүстинг ХХК, Стора Централ ХХК гэсэн охин компаниудтай болсон.
4. Компанийн оноосон нэрийг Премиум Нэксус ХК, Компанийн оршин байгаа хаягийг Монгол Улс, Улаанбаатар 13312, Баянзүрх дүүрэг, 26-р хороо, Олимп хороолол, Их Монгол Улсын гудамж 202, Сакура Тауэр, 7-н давхар болгон өөрчилсөн.
5. Компанийн бүтэц зохион байгуулалтын өөрчлөлттэй холбоотойгоор А.Ганхуягийг Компанийн Гүйцэтгэх захирлаар, Г.Чинзоригийг Гүйцэтгэх захирлын орлогчоор, Г.Бат-Эрдэнийг Санхүү хариуцсан захирлаар, Гари Стивен Биондо (Gary Stephen Biondo)-г ТУЗ-ийн (хараат бус) даргаар тус тус томилсон.
6. Компанийн 100 хувийн хөрөнгө оруулалттай, хүнсний бөөний болон жижиглэн худалдаа, хүнсний агуулахын болон тээврийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах Премиум Коммерс ХХК, тээвэр ложистикийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах Премиум Нэксус Ложистикс ХХК-иудыг үүсгэн байгуулсан.
7. 2023 оны 12-р сарын 04-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын шийдвэрийн дагуу хувьцааг хаалттай хүрээнд нэмж гаргах замаар шилжүүлж авсан эд хөрөнгөтэй холбогдуулан байгуулсан ерөнхий нөхцөл бүхий гэрээний заалтын дагуу Чингис Шар Айраг ХХК болон Сэнтрал Коммерс ХХК-ийн нийт гаргасан хувьцааны 16.7 хувийг Д.Очирхуяг, Вэйв Три Инвестмент Партнерс ХХК-д, Сэнтрал Кофе Рөүстинг ХХК-ийн нийт гаргасан хувьцааны 9 хувийг Вэйв Три Инвестмент Партнерс ХХК-д тус тус шилжүүлсэн бөгөөд хувьцааны шилжүүлгийн дараах байдлаар Компани нь Чингис Шар Айраг ХХК-ийн нийт гаргасан хувьцааны 83.2 хувийг, Сэнтрал Коммерс ХХК-ийн нийт гаргасан хувьцааны 83.2 хувийг, Сэнтрал Кофе Рөүстинг ХХК-ийн нийт гаргасан хувьцааны 90.9 хувийг тус тус эзэмших болсон.

8. Компанийн эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг шинэчилж Гүйцэтгэх захирал А.Ганхуяг, Гүйцэтгэх захирлын орлогч Г.Чинзориг, Санхүү хариуцсан захирал Г.Бат-Эрдэнэ, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Т.Гантулга нарыг компанийн эрх бүхий албан тушаалтан болохыг тодорхойлсон.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Г.Чинзориг

Албан тушаал: Премиум Нэксус ХК-ийн Гүйцэтгэх захирлын орлогч

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)



Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Д.Бүдханд

Албан тушаал: Премиум Нэксус ХК -ийн Санхүүгийн газрын захирал, Бизнес Контроллер

Гарын үсэг:



ПРЕМИУМ НЭКСУС ХК

2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Ирээдүйг чиглэсэн мэдэгдлийн талаарх анхааруулга

Премиум Нэксус ХК нь энэхүү тайланд “ирээдүйг чиглэсэн” зарим мэдэгдэл агуулагдсан болно. Тухайлбал, тус тайланд “бид таамаглаж байна, бид тооцоолж байна, бид зорьж байна, бид төлөвлөж байна” гэх мэт үгстэй ойролцоо үг, мөн ирээдүй цагийг илэрхийлэх үгс ашиглагдсан болно. Ирээдүйг чиглэсэн мэдэгдэл нь ирээдүйд болох үйл явдал, нөхцөл байдлын баталгаа биш бөгөөд бидний таамагласан нөхцөл байдал биелэхгүй байх магадлалтай ба тэдгээр таамаглалуудад хэт найдах нь учир дутагдалтайг анхаарна уу.

Компанийн бизнесийн үйл ажиллагааны цаашдын чиг хандлага нь эрсдэл, тодорхойгүй байдал гэх мэт хүчин зүйлс, мөн үүгээр хязгаарлагдахгүй зүйлсээс хамаарч материаллаг зөрүүтэй байж болно. Тиймээс, эдгээр эрсдэл болон тодорхойгүй байдлыг харгалзан үзэж ирээдүйг чиглэсэн мэдэгдэл, төсөөллийг шууд утгаар нь бодитоор биелнэ хэмээн авч үзэх нь өрөөсгөл юм. Мөн, компанийн зүгээс шинэ мэдээ мэдээлэл болон ирээдүйд гарах ялгаатай үр дүн эсвэл аливаа бусад шаардлагын улмаас энэхүү тайланд тусгагдсан ирээдүйд чиглэсэн таамаглалуудыг шинэчлэх эсвэл засварлах аливаа үүрэггүй болохыг мэдэгдэж байна.

Агуулга

- Компанийн тухай
- Хувьцаа эзэмшигчдийн хурал, хувьцаа
- CU Конвиниенс дэлгүүрийн бизнес
- 2024 оны эхний хагас жилийн онцлох үйл явдлууд
- Нэгтгэсэн санхүүгийн үзүүлэлтүүдийн товч танилцуулга

Премиум Нэксус ХК-ийн удирдлага



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Төлөөлөн удирдах зөвлөл

А. Ганхуяг

Гүйцэтгэх захирал (CEO)

Г. Чинзориг

Гүйцэтгэх захирлын орлогч
(Deputy CEO)

Г. Бат-Эрдэнэ

Санхүү хариуцсан захирал
(CFO)


Н. Энхболд

Портфолио хариуцсан захирал
(EVP Portfolio)

С. Дашдорж

Коммерс хариуцсан захирал
(MD Commerce)

Премиум Нэксус ХК-ийн бизнесийн бүтэц



Хөгжлийн үе шат болон Премиум Нэксус

Премиум Корпорэйшн 2015 онд өөрийн 100%-ийн хөрөнгө оруулалтаар Централ Экспресс нэршлээр Монголын анхны конвиненс дэлгүүрийг нээж байв. 2017 онд Централ Экспресс Си Ви Эс ХХК-ийг байгуулж, 2018 оны 8-р сард дэлхийн конвиненс дэлгүүрийн жишиг стандартын төлөөлөл болох БНСУ-д 18,000 орчим дэлгүүрээр зах зээлийг манлайлагч CU брэндийн үүсгэн байгуулагч БНСУ-ын жижиглэн худалдааны тэргүүлэгч Би Жи Эф Ритэйл ХК-иас Централ Экспресс Си Ви Эс ХХК-ийн 10%-ийг эзэмших стратегийн хөрөнгө оруулалт татаж, хамтдаа CU брэндийг Монголд нэвтрүүлсэн.

2021 онд Централ Экспресс Си Ви Эс ХХК нь Монголын Хөрөнгийн Бирж дээр IPO амжилттай хийж хувьцаат компани болсон ба улмаар 2023 оны эцэст хувьцаа эзэмшигчдийн хурлаар хөгжлийн дараагийн шатандаа гарах шийдвэрийг баталж нэрээ Премиум Нексус ХК болгон өөрчилжээ. Уг өөрчлөлтийн эхлэл нь шинээр хувьцаа гаргах замаар босоо интеграцийн хөрөнгө оруулалт болох Чингис Шар Айраг ХХК, Централ Коммерс ХХК, Централ Кофе Рөүстинг ХХК болон Стора Централ ХХК нарыг нэгтгэсэн явдал юм.



Хоолны үйлдвэр, нэгдсэн түгээлтийн систем, 393 салбар дэлгүүртэй конвиниенс сүлжээ дэлгүүрийн үйлчилгээ.

CU сүлжээ төвтэй, өргөн хүрээний нэгдсэн нийлүүлэлтийн гинжин хэлхээтэй цогц эко систем.

Премиум Нэксус экосистем ба түүний давуу талууд

1 Борлуулалт болон ашигт ажиллагааны өсөлт

Ханган нийлүүлэгчдийн хувьд CU сүлжээ дэлгүүртэй хамтран борлуулалтын прогнозоо улам оновчлох, эрэлтээ зөв таамаглах, үргүй зардлаа бууруулах боломжтой болсноор хамтын ашигт ажиллагаа нэмэгдэх болно.

2 Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж

CU сүлжээ дэлгүүр үйлдвэрлэгчидтэйгээ хамтран бүтээгдэхүүн хөгжүүлснээр хэрэглэгчдийн хэрэгцээнд бүрэн нийцсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх боломж бүрдэнэ. Ингэснээр хэрэглэгчийн сэтгэл ханамжийг өндөр түвшинд хүргэх, үнэнч хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэх боломжтой.

3 Хөрөнгө оруулагчдын нэгдмэл ашиг сонирхол

CU сүлжээ дэлгүүрийг түшсэн, түүнтэй хамаарал бүхий бизнесүүдийг нэг дор нэгтгэснээртэдгээр бизнесүүд хамтын хүчээр үлэмж үнэ цэнийг бий болгох боломжтой. Ингэснээр хөрөнгө оруулагчид энэхүү синергээс бий болох бүх боломжийг хүртэх нөхцөл бүрдэнэ.

4 Байгал орчин, Нийгэм, Засаглалын өндөр стандарт өргөн цар хүрээ

CU сүлжээ дэлгүүрийн ханган нийлүүлэгчид, ялангуяа жижиг дунд үйлдвэрлэгчид энэхүү эко-системд нэгдсэнээр, Премиум Нэксусийн олон улсын жишигт нийцсэн БОНЗ-ын практикийг өөрийн үйл ажиллагаандаа нэвтрүүлэх боломж бүрдэнэ.

5 Ложистик болон нэгдсэн түгээлтийн үр ашиг

Премиум Нэксус нь түгээлтийн нэгдсэн дэд бүтцийг хийснээр нийтлэг үр ашиггүй зардлыг бууруулж, эдийн засаг, байгал орчны эерэг нөлөөлөл бий болгоно.

6 Ажиллагсдын өсөж дэвших боломж, сэтгэл ханамж

Монголын хурдацтай өсөж буй нэр хүнд бүхий компанийн гишүүн болж ажиллах, групп компани дотроо өсөж хөгжих, Премиум туршлагаас суралцах зэрэг боломжууд ажиллагсдад нээлттэй болно.

Хувьцаа эзэмшигчдийн хурал


Компанийн хувьцаа эзэмшигчдийн эрхээ хэрэгжүүлэх гол хэлбэр нь хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хурлаар Компанийн тухай хууль болон Компанийн Дүрмийн холбогдох заалтуудын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлуудыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлдэг.

Компанийн тухай хуулийн холбогдох заалтууд, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-өөс баталсан Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах журам болон Санхүүгийн зохицуулах хорооны Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын дагуу Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04-р сарын 25-ны өдрийн 11:00 цагт амжилттай зохион байгуулсан бөгөөд тус хуралд нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 89.04 хувь нь оролцож Компанийн 2023 оны жилийн үйл ажиллагааны тайлан болон 2023 оны санхүүгийн жилийн цэвэр ашиг (алдагдал)-аас ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн шийдвэр, түүний шалтгаантай танилцаж, 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг танилцуулан батлав.

Үзүүлэлт	2023	2024
Нийт хувьцааны тоо	817,768,643	1,114,252,034
Хувьцаа эзэмшигчийн тоо	9,615	9,300
ХЭХ ирц	84.94	89.04



Индексжүүлсэн хувьцааны өгөөжийн гүйцэтгэл 2024 оны хагас жилээр



CU конвениенс дэлгүүрийн Алсын хараа, Эрхэм зорилго



Эрхэм зорилго

Дэлхийн стандартын үйлчилгээгээр хүмүүсийн өдөр тутмын амьдралыг хялбаршуулна



Алсын хараа

Үйлчилгээгээрээ дэлхийд танигдана




Үнэт зүйл, бизнесийн үзэл баримтлал

Бидний эрхэмлэх 4 үнэт зүйлс :

- АМЖИЛТ ГАРГАГЧ
- ӨСӨХ СЭТГЭЛГЭЭТЭЙ
- ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ ТӨВТЭЙ
- ШИЛДЭГ ХАМТРАГЧ


Үйл ажиллагааны онцлог, давуу тал



Конвениенс дэлгүүрүүд нь үйлчлүүлэгчдэд хамгийн ойр, үргэлж нээлттэй байж хэрэглэгчдийн хэрэгцээт бүтээгдэхүүн, үйлчилгээг тогтмол нийлүүлдгээрээ онцлогтой. Премиум Нэксус ХК нь CU брэндийн конвениенс дэлгүүрээр дамжуулан хэрэглэгчдийн өдөр тутмын амьдралд хэрэгцээт бүтээгдэхүүн үйлчилгээг 24 цагийн түрш хамгийн тав тухтай, хүртээмжтэй хүргэхээр зорин ажиллаж байна. Бид бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчдэд тасалдалгүй тогтмол хүргэж, тэдний сэтгэл ханамжийг хамгийн өндөр түвшинд байлгахын тулд бүтээгдэхүүн үйлчилгээний ялгарал, логистик, технологийн цогц шийдлийг бий болгон ажиллаж байна.

CU Конвениенс дэлгүүрийн үйл ажиллагааны гол үзүүлэлт


Үйлчлүүлэгчдийн тоо (сая)




2024 оны эхний хагас жил

Улаанбаатар	+23
Орон нутаг	+5

Ажиллагсдын тоо




Дэлгүүрийн тэлэлт




Замын-Үүдэд CU конвениенс дэлгүүр нээгдлээ

CU конвениенс дэлгүүр 2024 оны 4-р сард Замын-Үүд хотод шинэ салбараа нээлээ. Шинээр нээгдэж буй Замын-Үүд салбар нь аймгийн иргэд, худалдаа эрхлэгчид, хот хооронд зорчигчдод CU конвениенс дэлгүүрийн стандарт үйлчилгээг улам бүр ойртуулж, тав тухтай орчинд чанартай үйлчилгээ авах боломжийг олгож байна.

CU брэндийн салбар дэлгүүрийг Замын-Үүд хотноо нээснээр шинээр ажлын байр бий болгож, орон нутгийн бизнес эрхлэгчидтэй хамтран ажиллах үүд хаалга нээгдэж байна. Мөн конвениенс дэлгүүрийн үйлчилгээг Монгол орны өнцөг булан бүрд хүргэж, үйлчилгээний шинэ соёлоор түүчээлэх ажлыг улам бүр хурдасгаж байна.



Замын-Үүд салбарын нээлтэд CU конвениенс дэлгүүрийн баг бүрэлдэхүүн, аймгийн бяцхан хэрэглэгчид хамтран түүз хайчилж, дэлгүүрийн үйл ажиллагааг халуун дотноор эхлүүллээ.



Зах зээлийн тэлэлт

Улаанбаатар хот

2024 оны эхний хагас жилд бүгдэд хүртээмжтэй тэлэлт хийх бодлогыг хэрэгжүүлж хотын төвийн бүсээр 12 салбар дэлгүүр, хотын зах болон хотоос гарах зам дагуу 11 салбар дэлгүүрүүдийг нээж, хэрэглэгчдэд CU брэндийн стандарт үйлчилгээг үзүүлж байна.

Орон нутаг

Улаанбаатар хотоос 660 км орчим зайд орон нутгийн дэлгүүрүүдийг нээж, өдөр бүр хоолны үйлдвэр болон түгээлтийн төвөөс шинэхэн хоол, хэрэгцээт бараа, бүтээгдэхүүнийг тасралтгүй нийлүүлэн CU брэндийн стандарт үйлчилгээг орон нутгийн хэрэглэгчдэд үзүүлж байна.

Хэнтий аймаг Цэнхэрмандал сум, Дорноговь аймаг Замын-Үүд хот, Сайншанд сум, Архангай аймаг Хотонт сум.

Snack Library – 300 анхны консепт дэлгүүр

CU конвениенс дэлгүүрийн анхны консепт дэлгүүр "Snack Library"-г 300 дахь салбар болох Гэрлүг Виста салбарт нээгдлээ. Бусад салбаруудад худалдаалагддаггүй олон төрлийн шинэлэг сонголт бүхий амттангуудыг энэ салбараас сонгон худалдан авалт хийх боломжтой.



Ирээдүйд бэлтгэх франчайз хөтөлбөр

Тогтвортой хөгжлийн 17 зорилтуудыг ханган ажиллах зорилтын хүрээнд чанартай боловсролыг дэмжин ажиллахад хүртээмжтэй, тогтвортой өсөлтөд чиглэсэн төсөл, хөтөлбөрүүд санаачлан хэрэгжүүлэгч Боловсролын Санаачилгууд ТББ-ын "Ирээдүйд бэлтгэх франчайз хөтөлбөр"-ийг 2024 оны 2-р улирлаас дэмжин ажиллалаа.

Нийтийн тээврийн Umoney картаа CU орохдоо цэнэглэх боломжтой боллоо

2024 оны 04-р сараас эхлэн CU конвениенс дэлгүүрийн 250 салбараас Umoney картыг худалдан авах, цэнэглэх боломжтой болж үйлчилгээ иргэдэд илүү ойр, улам л хүртээмжтэй болсоор байна.

Салбар дэлгүүрээр том хүн болон хүүхдийн картыг 3,600 төгрөгөөр худалдаалж байна. Карт худалдан авах, цэнэглүүлэхдээ төлбөрөө бэлэн мөнгө эсвэл банкны картаар төлөх боломжтой.

Umoney картыг гаргагч компани болох Улаанбаатар Смарт Карт ХХК болон CU ая тухтай дэлгүүрийн үйлчилгээ үзүүлэгч Премиум Нэксус ХК нь 2018 оноос хойш хамтран ажиллаж байгаа ба цаашдаа хамтын ажиллагаагаа илүү өргөжүүлэхээр ажиллаж байна.



“Үзүүлээд өгье” аяныг эхлүүлээ

CU брэнд нь дэлхийн стандартад нийцсэн үйлчилгээ, тав тухтай орчин, найрсаг соёлтой үйлчилгээг нэвтрүүлж, их хотын залуусын амьдралын хэв маягт эерэг өөрчлөлт авчрах шинэлэг ажлуудыг санаачлан хэрэгжүүлдэг. Энэ удаад насанд хүрээгүй хүүхдүүдийг электрон болон утаат тамхи, согтууруулах ундаа худалдан авахаас урьдчилан сэргийлэх, өсвөр насны хүүхдүүдийн тамхидалтыг бууруулах зорилгоор “Үзүүлээд Өгье” аяныг эхлүүлээ.

“Үзүүлээд өгье” аяныг хэрэгжүүлснээр одоо мөрдөж буй тамхины хяналтын тухай хууль, архидалттай тэмцэх хуулийн хэрэгжилтийг хангаад зогсохгүй, жижиглэн худалдааны салбарт шинэ жишиг тогтоох, цагаа олсон хариуцлагатай ажил болно гэж харж байна.

CU конвениенс дэлгүүр жижиглэн худалдааны байгууллагууд, худалдаа эрхлэгчдийг энэхүү аянд нэгдэж, “Үзүүлээд өгье” аяны уриалгыг дэмжин ажиллахыг уриаллаа.

Мегабаллотерейн биет тасалбарыг CU конвинеенс дэлгүүрээр худалдаалж эхэллээ

Монголын анхны нэг ТЭРБУМ ТӨГРӨГ-ийн шагналын сантай Мегабаллотерейн биет тасалбарыг CU конвинеенс дэлгүүрээр худалдаалж эхэллээ. Тодруулбал, CU брэндийн мастер франчайз эрх эзэмшигч Премиум Нэксус ХК болон Мегаболл ХХК хамтран ажиллах гэрээ байгуулж, Мегабаллотерейн биет тасалбарыг CU конвинеенс дэлгүүрээр дамжуулан худалдаалж эхэллээ. Мегабаллотерей нь анх 2022 оны 12 дугаар сард хэрэглэгчдэд хүрч эхэлсэн бөгөөд цахим төлбөр тооцооны Нирау аппликейшнд байршдаг ба оролцогчид лотерейн зургаан тоог автоматаар сонгох, эсвэл өөрөө бөглөх сонголттой юм.

Харин өнөөдрөөс ийнхүү биет тасалбарын сонголтыг нэвтрүүллээ. Биет тасалбарыг бөглөхөд заавал ухаалаг утасны апп шаардлагагүй бөгөөд танд азаа үзэхэд илүү хялбар, илүү ойр болж байгаагаараа онцлог юм.


Америк стандартыг бүрэн хангасан нийгэмд тустай Мегабаллотерей нь Улаанбаатар хот дахь CU конвинеенс дэлгүүрийн 100 салбараар Мегабаллотерейн биет тасалбарыг борлуулж, хэрэглэгч өөрт хамгийн ойр салбарыг сонгон өөрийн азийг үзэх боломжийг олгож байна.



Сэнтрал Фүүдс ХХК нь нэгдсэн стандартын болон бүтээгдэхүүн үйлчилгээний баталгаажуулалтын тохирлын гэрчилгээг гардан авлаа

Сэнтрал Фүүдс ХХК буюу CU Хоол үйлдвэрлэлийн төв нь 2023 онд олон улсын HACCP стандартыг баталгаажуулан гэрчилгээтэй Монголын анхны хоол үйлдвэрлэл болж чадсан билээ. Монголын Үндэсний Итгэмжлэлийн Төвөөр итгэмжлэгдсэн Монсертф ХХК нь Сэнтрал Фүүдс ХХК-ийн хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд нэгдмэл тохирлын үнэлгээ буюу нэгдсэн менежментийн тогтолцооны аудитыг, бүтээгдэхүүн үйлчилгээний тохирлын үнэлгээг түүхий эд хүлээн авахаас эхлээд, эцсийн бүтээгдэхүүн бэлэн болох хүртэлх процессын үе шатанд цогцоор нь хийж, гүйцэтгэлээ.

Үүгээр менежментийн тогтолцооны 3 стандарт, зохистой дадлын стандарт, хоол үйлдвэрлэлийн стандартын нийт 121 шалгуурын дагуу явуулсан уг цогц аудитын үр дүнд Сэнтрал Фүүдс ХХК-д нэгдсэн стандартын 3 гэрчилгээ мөн бүтээгдэхүүн үйлчилгээний баталгаажуулалтын тохирлын гэрчилгээг тус тус олголоо. Ингэснээр Сэнтрал Фүүдс ХХК-ийн хоол үйлдвэрлэл нь нийт 5 стандартыг ханган ажиллаж буйгаа баталгаажуулсан анхны хоол үйлдвэрлэлийн байгууллага боллоо.



Сэнтрал Коммерс ХХК нь Asahi Super Dry "Cherry blossom" савлагаатай шар айргийг танилцууллаа

Сэнтрал Коммерс ХХК нь Японы №1 Asahi Super Dry шар айргийг албан ёсны эрхтэйгээр 2023 оны 9-р сараас эхлэн Монголын хэрэглэгчдэд хүргээд байгаа билээ. 2024 оны 4-р сард Asahi super dry шар айргийн шинэ лимитэд хувилбар болох "Cherry blossom" савлагаатай шар айргийг танилцууллаа. Энэ үйл ажиллагааны хүрээнд Шангри-Ла Төвийн үндсэн талбайд 3 хоногийн түрш POP-UP дэлгүүр байршуулан Asahi брэндийн сурталчилгааг хийж, Японы хаврын цэцэг дэлгэрэх цагийн уур амьсгалыг бүрдүүлж чадсан юм.

Цаашдаа хамтын ажиллагаагаа өргөжүүлэн бусад дэлхийн алдартай шар айраг болон ундааны зүйлсийн бүтээгдэхүүнүүдийг оруулж ирэхээр ажиллаж байна.



The Golden Duck брэндийн албан ёсны дистрибьютор боллоо

Сэнтрал Коммерс ХХК нь дэлхийн шилдэг брэндүүдийг Монгол хэрэглэгчдэдээ хүргэхийг зорин ажилладаг бөгөөд 2024 оны 6-р сараас эхлэн дэлхийн 20 гаруй орны сая сая хүмүүсийн таашаалд нийцсэн The Golden Duck брэндийн 4 нэр төрөл бүхий шинэ бүтээгдэхүүнийг албан ёсны эрхтэйгээр Монгол хэрэглэгчдэдээ нийлүүлж эхэллээ.

Golden Duck чипсний шинэчлэлтүүд нь илүү амтыг бий болгосноор дэлхийн өнцөг булан бүрд шинэ амтаараа гайхшируулж байна!



Сэнтрал Коммерс ХХК нь орон нутгийн албан ёсны гэрээт борлуулалтын сувагтай боллоо

Сэнтрал Коммерс ХХК нь 5-р сараас эхлэн орон нутгийн гэрээт дистрибьютер компанитай болсноор Асахи брэндийн борлуулалтын сувгийг тэлж орон нутгийн хэрэглэгчдэдээ шуурхай түргэн бүтээгдэхүүнээ нийлүүлж эхлээд байна.

2024 оны 5-р сарын 23-24-ний өдрүүдэд Дархан, Эрдэнэт салбарын нийт 100 гаруй харилцагчдад Асахи брэндийн танилцуулга сургалт орж, хэрэглэгч рүү чиглэсэн арга хэмжээг зохион байгуулсан юм.



Сентрал Кофе Рөүстинг ХХК нь СУ-гийн бүх салбаруудаар хуурсан үр нийлүүлж эхэллээ

Сентрал Кофе Рөүстинг ХХК нь 2024 оны 5-р сараас эхлэн СУ-ийн бүх салбаруудаар хуурсан үр нийлүүлж эхэллээ. Хэрэглэгчдэд хэдийнээ танил болсон GET Coffee-ны хуурсан үрийг Солонгос улсаас импортлон оруулж ирдэг байсан бол 2024 оны 2-р улирлаас эхлэн шинэ үрийн ногоон кофег гарал үүслээс нь импортлон, дэлхийн шилдэг Герман технологиор эх орондоо хуурч, СУ-ийн 393 салбар дэлгүүрүүдээр хэрэглэгчдэд хүргэдэг боллоо.

Манай ногоон кофены нийлүүлэлтийн түнш нь дэлхийн кофе үйлдвэрлэгч гол орнуудад үйл ажиллагаагаа явуулдаг, ёс зүйтэй, тогтвортой, байгаль орчинд ээлтэй ногоон үрийн нийлүүлэлтийн сүлжээг бүрдүүлсэн, кофены гарал үүслийн орнуудын 85% -ийг хамруулсан бизнес бүхий дэлхийн шилдэг худалдааны компани юм.

Бид худалдан авсан ногоон үрээ Герман улсын дэлхийн шилдэг Пробат төхөөрөмжийг ашиглан хуурдаг бөгөөд хууралтын профайл, процесс, чанар, хүнсний аюулгүй байдлын стандарт, шаардлагуудыг ханган хуурах, савлах үйл ажиллагааг явуулж байна.





Stora.mn-ээр дамжуулан Хятад улсаас хүссэн бараагаа захиалах боломжтой боллоо

Stora Централ ХХК-ийн Stora.mn онлайн худалдааны платформоор дамжуулан Америкаас бараа захиалдаг байсан бол 2024 оны 1-р сараас эхлэн Хятадын хамгийн том онлайн худалдааны сайт болон Taobao-гоос бараа захиалах боломжтой боллоо. Ингэснээр Стора-гийн хэрэглэгчид Хятад улсын нийт 3.7 тэрбум бараанаас Монгол хэл дээрээ, төгрөгийн төлбөрийн хэрэгслээ ашиглан, бараа буцаалтын боломжтой, найдвартай ая тухтай үйлчилгээгээр хангагдаж байгаа юм.



Storepay хуваан төлөлтийн шийдэл Стора-д амжилттай нэвтэрлээ

Гадаадаас бараа худалдан авахад хуваан төлнө гэдэг ойлголт огт байдаггүй байсныг өөрчилж Storepay-ийн хуваан төлөлтийн шийдлийг stora.mn өөрийн үйлчилгээнд нэвтрүүллээ. Ингэснээр Стора-гийн хэрэглэгчид ямар ч хүү, шимтгэл болон бусад нэмэлт төлбөргүйгээр Америк болон Хятадаас хүссэн бараагаа хуваан төлж авах боломжтой боллоо.

Барилгын салбарт хийгдсэн цоо шинэ шийдэл

Барилгын материал тэр дундаа өөрийн хувийн байшинг барих, засах, хашаагаа тохижуулах, тоглоомын талбай хийхэд ашиглах бетоныг гар утас, хувцас авч байгаатай яг ижилээр онлайн худалдааны платформуос авах цоо шинэ шийдлийг бетон зуурмагийн масс үйлдвэрлэлийн цогц үйлчилгээг хүргэж буй Премиум Бьюлдинг Материалс ХХК болон Стора Централ ХХК хамтран нэвтрүүллээ.

Өөрийн хувийн хэрэгцээ, барилгын бригад, томоохон төсөл хэрэгжүүлэгч хэн бүхэн Stora.mn платформуор дамжуулан ердөө 4 алхмаар өөрт хэрэгтэй бетон зуурмагийг захиалан, хүргүүлэн авах боломжийг 8 дахь удаагийн Төгс Бүтээгч эвент дээр хоёр компани хамтран танилцууллаа.



СТОРА АПП

АМЕРИК, ХЯТАДААС ХҮССЭНЭЭ ЗАХИАЛААРАЙ



Стора аппликейшн нээлтээ хийлээ

Стора Централ ХХК удаан хүлээлгэсэн өөрийн аппликейшнээ нээж цоо шинэ UX/UI бүхий апп аа зах зээлд танилцууллаа. Уг аппликейшнийг татсанаар хэрэглэгчид www.stora.mn дээр байгаа бүхий л үйлчилгээг ижил авах бөгөөд Америк болон Хятадын нийт 2.5 тэрбум бараанаас хүссэнээрээ сонгон худалдан авах мөн зээлээр болон хуваан төлөх нөхцөлтэй төлбөрийн шийдлийг ашиглах боломжтой.

Чингис Шар Айраг ХХК

Чингис Шар Айраг ХХК нь 1997 онд үүсгэн байгуулагдсан ба Монгол Улсын шар айраг үйлдвэрлэлийн салбарт ХБНГУ-ын технологийг ашиглан, "Reinheitsgebot" буюу Шар айргийн цэвэр тунгалгийн хуулийн дагуу үйлдвэрлэдэг Пилснэр төрлийн, амьд, задгай шар айргийг амжилттайгаар таниулсан үндэсний шилдэг аж ахуйн нэгжийн нэг юм.

Чингис Шар Айраг ХХК нь үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш Монгол Улсынхаа цэвэр цэнгэг усыг Европын өндөр зэрэглэлийн түүхий эдийн хамтаар үйлдвэрлэлдээ ашиглан, харилцагчдадаа үйлдвэрлэгдсэн өдөрт нь түгээлт хийн ажиллаж байна.

Чингис Шар Айраг ХХК нь зах зээлд бүтээгдэхүүний чанараараа манлайлах, эцсийн хэрэглэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх болон хэрэглэгчдэд илүү хүртээмжтэй болох зорилгоор 2024 оны эхний хагаст борлуулалтын цэгийн тоог Улаанбаатар хот болон хөдөө орон нутгуудаар нэмэгдүүлж, тус цэгүүд дээр эцсийн хэрэглэгчдэд үйлчилж буй ажилтнуудад сургалт, зөвлөмж, зөвлөгөөний давтамжийг нэмэгдүүлэхээс гадна, байршуулсан тоног төхөөрөмжийн засвар, цэвэрлэгээ үйлчилгээний давтамжийг нэмэгдүүлэх тал дээр анхаарч ажиллаж байна.



Чингис Шар Айраг илүү хүртээмжтэй боллоо

Чингис шар айраг ХХК-иас хэрэглэгчдэд хүртээмжтэй байдлаа нэмэгдүүлэх үүднээс 2 литрийн хэмжээтэй шинэ төрлийн савлагааг зах зээлд нэвтрүүлэхээр ажиллаж байна. Ингэснээр эцсийн хэрэглэгчид Чингис шар айргийг зөвхөн худалдаалагдаж буй бар, ресторанд үйлчлүүлэх замаар хэрэглэхээс гадна, гэртээ, хөдөө орон нутгаар явах үедээ ч авах боломжтой боллоо.

ПРЕМИУМ НЭКСУСИЙН НЭГТГЭСЭН ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ТОВЧ ТАЙЛАН

(Сая төгрөгөөр)	2022Н1	2022Н2	2023Н1	2023Н2	2024Н1
Нийт цэвэр борлуулалт	111,166.4	149,852.5	167,246.8	223,249.8	263,631.9
Борлуулалтын өртөг	103,951.6	144,778.0	161,315.2	206,327.8	217,698.5
Нийт ашиг (алдагдал)	7,214.7	5,074.5	5,931.6	16,921.9	45,933.3
<i>Нийт ашгийн хувь</i>	6.5%	3.4%	3.5%	7.6%	17.4%
Үйл ажиллагааны зардал	3,181.8	6,131.8	4,336.2	6,786.4	8,991.1
ХТЭХӨАшиг	4,032.9	(1,057.3)	1,595.5	10,135.5	36,942.2
<i>ХТЭХӨАшгийн хувь</i>	3.6%	-0.7%	1.0%	4.5%	14.0%
Элэгдэл Хорогдол	7,235.7	10,683.9	12,817.9	14,738.8	15,965.7
ХТӨАшиг	(3,202.8)	(11,741.2)	(11,222.4)	(4,603.4)	20,976.5
Санхүүжилтийн зардал	3,796.8	7,350.8	8,165.4	9,341.1	9,746.0
Татварын өмнөх ашиг	(6,999.6)	(19,092.0)	(19,387.8)	(13,944.5)	11,230.5
Татварын зардал	94.6	(501.8)	(14.8)	(611.1)	578.0
Цэвэр ашиг/алдагдал	(7,094.3)	(18,590.1)	(19,373.0)	(13,333.3)	10,652.5
<i>Цэвэр ашгийн хувь</i>	-6.4%	-12.4%	-11.6%	-6.0%	4.0%

Тайлбар: Аудитлагдаагүй санхүүгийн тайлангийн үзүүлэлт

ПРЕМИУМ НЭКСУСИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

(Сая төгрөгөөр)	2022Н1	2022Н2	2023Н1	2023Н2	2024Н1
Эргэлтийн хөрөнгө	38,382.2	44,439.9	37,645.9	40,170.3	62,036.9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3,863.1	4,280.7	2,389.8	2,980.6	7,088.5
Дансны авлага	494.4	432.7	372.0	653.7	3,374.8
Бараа материал	23,417.8	31,838.4	27,855.9	28,250.0	34,354.2
Бусад эргэлтийн хөрөнгө	10,606.9	7,888.1	7,028.2	8,285.9	17,219.5
Эргэлтийн бус хөрөнгө	112,461.1	126,608.8	140,061.2	153,324.6	182,210.9
Биет болон биет бус хөрөнгө	71,942.8	73,192.6	80,535.2	90,196.5	114,667.5
Ашиглах эрхтэй хөрөнгө	33,739.6	46,960.5	49,771.2	50,532.2	51,367.7
Бусад эргэлтийн бус хөрөнгө	6,778.7	6,455.6	9,754.8	12,595.9	16,175.7
НИЙТ ХӨРӨНГӨ	150,843.3	171,048.7	177,707.1	193,494.9	244,247.9

Тайлбар: Аудитлагдаагүй санхүүгийн тайлангийн үзүүлэлт

ПРЕМИУМ НЭКСУСИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

(Сая төгрөгөөр)	2022Н1	2022Н2	2023Н1	2023Н2	2024Н1
Богино хугацаат өр төлбөр	46,886.4	73,761.6	82,073.1	116,172.9	84,272.1
Дансны өглөг	36,943.3	44,972.4	64,602.4	74,851.5	56,992.5
Богино хугацаат зээл	2,169.9	17,290.8	4,823.9	19,969.9	12,740.8
Бусад богино хугацаат өр төлбөр	7,773.2	11,498.4	12,646.8	21,351.4	14,538.9
Урт хугацаат өр төлбөр	55,486.3	78,849.4	96,569.4	91,590.7	98,607.7
Урт хугацаат зээл	14,441.5	27,932.9	36,371.2	33,882.0	30,995.4
Бусад урт хугацаат өр төлбөр	41,044.8	50,916.5	60,198.2	57,708.6	67,612.3
Эздийн өмч	48,470.6	18,437.6	(935.3)	(14,268.7)	61,368.1
Энгийн хувьцаа	81,776.9	81,776.9	81,776.9	81,776.9	111,425.2
Нэмж төлөгдсөн капитал	13,820.5	13,820.5	13,820.5	13,820.5	45,757.9
Эздийн өмчийн бусад хэсэг	11,558.6	318.7	318.7	318.7	3,717.2
Хуримтлагдсан ашиг	(58,685.3)	(77,478.5)	(96,851.4)	(110,184.8)	(99,532.3)
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	150,843.3	171,048.7	177,707.1	193,494.9	244,247.9

Тайлбар: Аудитлагдаагүй санхүүгийн тайлангийн үзүүлэлт

ПРЕМИУМ НЭКСУСИЙН НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

(Сая төгрөгөөр)	2022H1	2022H2	2023H1	2023H2	2024H1
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ					
Мөнгөн орлогын дүн (+)	125,358.8	165,659.0	189,164.7	240,620.1	300,144.7
Мөнгөн зарлагын дүн (-)	(119,373.0)	(163,536.5)	(180,819.6)	(229,742.4)	(267,487.8)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	5,985.8	2,122.5	8,345.1	10,877.8	32,657.0
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ					
Мөнгөн орлогын дүн (+)	19,742.6	6,710.7	53.7	55.4	1,277.5
Мөнгөн зарлагын дүн (-)	(19,434.8)	(20,808.2)	(12,108.6)	(17,184.8)	(11,032.0)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	307.9	(14,097.5)	(12,054.9)	(17,129.4)	(9,754.4)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ					
Мөнгөн орлогын дүн (+)	2,782.0	43,560.0	14,800.0	19,027.0	30,891.3
Мөнгөн зарлагын дүн (-)	(9,045.2)	(24,452.1)	(23,990.1)	(21,295.9)	(49,185.2)
Хоорондын тооцоо (+/-)	(111.9)	(6,558.3)	11,020.1	9,206.3	(429.2)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(6,375.1)	12,549.6	1,830.0	6,937.4	(18,723.0)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн гадаад валютын ханшийн зөрүү	(116.6)	(157.0)	(11.1)	(95.0)	(71.6)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(198.1)	417.6	(1,890.9)	590.8	4,107.9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,061.2	3,863.1	4,280.7	2,389.8	2,980.6
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,863.1	4,280.7	2,389.8	2,980.6	7,088.5

Тайлбар: Аудитлагдаагүй санхүүгийн тайлангийн үзүүлэлт



БАЯРЛАЛАА

Холбоо барих бол:
IR manager Ц. Номуундалай
И-мэйл: investor@cumongol.mn
Утас: 95109612